

ХАЛДВАРТ ӨВЧИНТЭЙ ТЭМЦЭХ, СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2025 ОНЫ БИЕЛЭЛТ

Орхон аймаг

2025.12.17

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Биелэлт, үр дүн	Хэрэгжилтийн хувь	
ЗОРИЛТ 1. ЭРҮҮЛ МЭНДИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛД НӨЛӨӨЛӨХ ШИНЭ СОРИЛТ БОЛЗОШГҮЙ ЦАР ТАХАЛ НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН НОЦТОЙ БАЙДЛЫН ҮЕИЙН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ БЭЛЭН БАЙДЛЫН ЧАДАВХЫГ НЭМЭГДҮҮЛЖ ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ТАНДАЛТ ХЯНАЛТЫН ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛЭХ.							
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ 1.1 ОЛОН УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ДҮРМЭЭР ЗОХИЦУУЛАГДДАГ ХАЛДВАРТ ӨВЧИН, НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНД НОЦТОЙ БАЙДАЛ ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ТАНДАЛТ ХЯНАЛТЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИНЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ							
1.1.1	Томуугийн тандалтын үйл бэхжүүлэх.	харуулдан нэгжүүдийн ажиллагааг	Дэмжлэгт хяналт, сургалтын тоо	2	4	Бүсийн оношилгоо эмчилгээний төв болон өрхийн эрүүл мэндийн төвүүдэд дотоодын 4, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн томуугийн үндэсний нэгжтэй хамтарсан 1, нийт 4 удаа дэмжлэгт хяналт хийж, тандалтын тоон мэдээллийг чанаржуулах, сорьц тээвэрлэлт, түргэвчилсэн шинжилгээг тогтмолжуулах чиглэлээр зөвлөмж өгч ажилласан. Орон нутгийн санхүүжилтаар өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 2000 ш түргэвчилсэн тест, БОЭТ-д 3 төрлийн тус бүр 250 ш ПГУ шинжилгээний оношлуураар хангасан. 2025/2026 оны тандалтын шинжилгээнд орон нутгийн төсвөөс 14,7 сая төгрөөр ПГУ оношлуур худалдан авсан.	100
1.1.2	Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед салбар хоорондын мэдээ, мэдээлэл солилцох, эрсдэлийн үнэлгээ хийх, хариу арга хэмжээ авах.	Хариу арга хэмжээний чадавх нэмэгдсэн байна.	96%	96.5%	Томуу, томуу төст өвчний бэлэн байдлыг хангах чиглэлээр аймгийн онцгой комиссын шийдвэрээр батлагдсан 131 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2000 ширхэг түргэвчилсэн оношлуур, 7 төрлийн багаж тоног төхөөрөмж, Н95 амны хаалт 1000ш худалдан авч, салбаруудад хуваарилсан. Орон нутгийн 2025 оны төсөвт нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед тохиолдол удирдлагын тогтолцоог дэмжих, томуу, томуу төст өвчний үеийн бэлэн байдлыг хангах зорилгоор 55 сая төгрөгийг суулгасан. Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх тохиолдлын удирдлагын багийг Эрүүл мэндийн газрын даргын 2025 оны А/97 дугаар тушаалаар шинэчлэн баталж, хариу арга хэмжээний үед шилжин ажиллаж байна.Томуу, томуу төст өвчний үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийн хурлыг 4 хийж, 9 асуудал хэлэлцэж, 10 шийдвэр гарган, хэрэгжилтийг 95,6% ханган ажилласан. Улаанбурхан өвчний дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээг аймгийн засгийн даргын 2025 оны А/586 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулж, салбар дундын уялдаа холбоог ханган ажилласан.“Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн тохиолдол удирдлагын тогтолцоо” сэдэвт сургалтыг зохион байгуулж,	100	

					онцгой байдлын газар, тагнуулын газар, цагдаагийн газрын удирдлага, мэргэжилтнүүд, сум, багийн засаг дарга, нийгмийн ажилтан, эрүүл мэндийн байгууллагуудын шуурхай удирдлагын багийн гишүүд, хүүхдийн байгууллагын эмч, нийт 145 хүнийг хамруулж, чадавхжуулсан. Хариу арга хэмжээний чадавх 1,5% нэмэгдэж, зорилтот түвшинд хүрсэн байна.	
1.1.3	Хүүхдийн байгууллага, хаалттай орчин (цэргийн хуаран, асрамжийн газар, хорих газар)-д халдварт өвчний тандалт хийх	Тандалтын тоо	1	2	Тайлант хугацаанд халдварт өвчний 593 тохиолдол бүртгэгдэж, өнгөрсөн оны мөн үеэс 2,1 промиллоор буурсан байна. Нийт халдварт өвчний 47,6% амьсгалын зам, 25,8% БЗДХ, 3% гэдэсний, 26,6% бусад халдварт өвчин байна. Мөн 5 төрлийн 228 хам шинж, сэжигтэй тохиолдол бүртгэгдэж, хариу арга хэмжээг авч ажилласан нь өнгөрсөн оны мөн үеэс 110 тохиолд тохиолдлоор их байна. Цэврүүт тууралт 40,8%, халууралт тууралт 21,5%, бусад хам шинж 37,7% тус тус байна. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх эрсдэлийг бууруулах чиглэлээр 2 удаагийн дэмжлэгт хяналт давхардсан тоогоор 31 сургууль, 39 цэцэрлэг хамрагдсан. Мөн 18 сургууль, 35 цэцэрлэгт цахимаар болон утсаар тандалт хийсэн. Ерөнхий боловсролын 17 сургууль, хүүхдийн 31 цэцэрлэг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 9 арга хэмжээ зохион байгуулж ажилласан. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдэд 63 удаагийн сургалт хийж, 3275 хамруулсан ба 2411 хүнд зөвлөгөө мэдээлэл өгч, 176 төрлийн гарын авлага 1223ш түгээсэн байна. Цахимаар 115 төрлийн зөвлөмж түгээж, 2034 хүнд хүргэсэн. Хүүхдийн ирцийн тандалтыг өдөр бүр хийж ажилласан. Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үед ирц 70-80% хүрсэн. Ирцийн тандалтад үе шатад тохирсон хариу арга хэмжээг тухай бүр хэрэгжүүлэн ажилласан. Улаанбурхан өвчний дэгдэлттэй холбоотой ирц буураагүй байна. Халууралт тууралттай халдварт өвчний тандалтыг 2 цэргийн анги, 1 хорих ангид хийж, сэжигтэй 2 тохиолдол илрүүлж, лабораторийн шинжилгээгээр онош үгүйсгэгдсэн. Сэжигтэй голомтын хариу арга хэмжээг зохион байгуулж, голомтын дархлаажуулалтад 100% хамруулсан. Энэрэл төвийн хүүхдүүдийн дунд халууралт, тууралттай хам шинж болон томуу, томуу төст өвчний тандалтыг тогтмол хийж байна.	100
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ 1.2. ОЛОН УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ДҮРМЭЭР ЗОХИЦУУЛАГДАХ ХАЛДВАРТ ӨВЧИН НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН НОЦТОЙ БАЙДАЛ ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЧАДАВХ САЙЖРУУЛАХ.						
1.2.1	Хоол, хүнс, ундны усаар дамжих халдварын дэгдэлтийн хариу арга хэмжээг зохион байгуулж, холбогдох байгууллагыг мэргэжлийн удирдлагаар хангах	Хариу арга хэмжээний хэрэгжилтийн хувь	95%	96%	Нийт халдварт өвчний 10% цусан суулга болон хоолны хордлого эзэлж, 10,0 хүн амд 0,8 тохиолдол буюу өнгөрсөн оны мөн үеэс 0,4 тохиолдлоор нэмэгдсэн байна. “Найрамдлын эрдэнэс” хүүхдийн зусланд бүртгэгдсэн хоолны хордлогын дэгдэлт бүртгэгдэж, 5-р ээлжид ажиллаж, амарч байсан 378 хүнээс, 339 (90%) хүнд тандалт судалгаа хийсэн. Тандалтад 289 амрагч хүүхэд, хоол үйлдвэрлэлийн 29 ажилтан, бусад 32 багш ажиллагсад хамрагдсан. Нийт өртсөн	100

					хүмүүсийн 259 (68%)-д эмнэлзүйн шинж тэмдэг илэрсэн, үүнээс Дөл бүлэг 85%, Найрамдал бүлэг 81%, Ирээдүй бүлгийн 80%, багш ажиллагсад – 52%, хоол үйлдвэрлэлийн ажилтнуудын 35% нь өртсөн байна. Тархвар зүйн тандалт судалгаа, өвчтөнд илэрсэн эмнэлзүйн шинж тэмдэг, эпидемийн муруй, нууц үеийн хугацаа, хоолны харьцангуй эрсдэл, нян судлалын шинжилгээний дүнг үндэслэн Найрамдлын эрдэнэс хүүхдийн зуслангийн багш ажилчид, хүүхдүүдийн дунд бохирлогдсон хоол, усаар дамжсан (Shigella.spp+ E.Coli+Campylobacter.spp)-оор үүсгэгдэж, хавсарсан хоолны хордлогот халдварын дэгдэлт тархсан байна гэж үзэж байна.	
1.2.2	Гамшиг нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн эрүүл мэндийн байгууллагуудын нөөцийг нэмэгдүүлэх.	Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн нөөцийн хангалтын хувь	95%	95.8%	ЭМГ-ын гамшгийн нөөц 12 нэр төрлийн 4.8 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж хэрэгсэл, 4.6 сая төгрөгийн яаралтай тусламжийн багц, 3 нэр төрлийн 27.0 сая төгрөгийн хувийн хамгаалах хувцас хэрэгслийн нөөц бүрдүүлсэн. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшиг, онцгой байдлын үеийн хариу арга хэмжээний чадавх 96,5% буюу өмнөх оноос 1,5% нэмэгдэж, зорилтот түвшинд хүрсэн байна.	100

ЗОРИЛТ 2. АНХАН ШАТНЫ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНД ТУЛГУУРЛАСАН ДАРХЛААЖУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАЖ ХЭНИЙГ Ч ОРХИГДУУЛАХГҮЙГЭЭР ХАМРУУЛАХ БОЛОМЖИЙГ БҮРДҮҮЛЭХ.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ 2.1. ДАРХЛААЖУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛЖ ДАГАЛДАХ ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧГИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ

2.1.1	Хүний папиллома вирусийн халдварын эсрэг вакцины хамралтын хувийг нэмэгдүүлэх.	Хамралтын хувь	20%	85%	Хүний папиллома вирусийн эсрэг вакцины хамралтыг нэмэгдүүлэх аяныг сум, өрхийн эрүүл мэндийн төв, ерөнхий боловсролын сургуулийн дунд зохион байгуулагдаж байна. Хүний папиллома вирусийн эсрэг вакцины хамралт 30% байна.. Дэлхийн дархлаажуулалтын 10 хоногоор “Дархлаажуулалтын ашиг тусыг хүн бүрд хүртээе” өдөрлөгийг Эрүүл мэндийн газар, сум, өрхийн эрүүл мэндийн төв 9, ерөнхий боловсролын сургууль 23 хамтран 4500 гуруй сурагч, 2700 гаруй эцэг, эх, асран хамгаалагч нарын төлөөлөл хамрагдсан. Мөн нөлөөллийн уулзалтад орон нутгийн удирдлагууд, төрийн болон төрийн бус байгууллага, эрүүл мэндийн салбарын төлөөлөл 100, сургагч багш бэлтгэх сургалтад сурагчид болон эцэг, эх, асран хамгаалагч нарын төлөөллөөс 200 багш бэлтгэн сургууль бүр арга хэмжээг хамтран зохион байгуулж ажилласан. Засаг даргын 2025 оны А/819 дүгээр захирамжаар ажлын хэсэг, төлөвлөгөө, үйл ажиллагааг зохион байгуулахад шаардагдах 8,5 сая төрөгийн санхүүжилтийг шийдвэрлэсэн. Ажлын хэсэг 1 удаа хуралдаж салбаруудад үүрэг чиглэл өгсөн. Ажлын хэсгийн хурлын шийдвэрийн дагуу ерөнхий боловсролын сургуулиудад үүрэг даалгавар албан	100
-------	--	----------------	-----	-----	--	-----

					тоотоор хүргүүлсэн. ЭМГ-ын даргын А/86 дугаар тушаалаар эцэг, эх, асран хамгаалагч нарт вакцины үр, дүн ач холбогдлыг таниулах ухаалга, нөлөөллийн арга хэмжээг төлөвлөгөөний дагуу зохион байгуулж байна. Манай аймагт товллын дагуу 2013 онд төрсөн 2417 хүүхдээс 1221(43.6%), 2014 онд төрсөн 2341 хүүхдээс 1114(60.4%), нийт хамрагдвал зохих 4758 хүүхдээс 2543 хүүхэд хамрагдаж, хамралт 55,2% байна. Дархлаажуулалтын хамралт 24,4% нэмэгдсэн байна	
2.1.2	Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед шаардлагатай дархлаажуулалтын шуурхай зохион байгуулах	Дархлаажуулалтын хамралтын хувь	79.5%	85%	Эрүүл мэндийн сайдын 2025 оны “Улаанбурхан өвчний дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээг эрчимжүүлэх” тухай А/223 дугаар тушаалын Улаанбурханы эсрэг вакцинаар 6-8 сартай хүүхдүүдийг улаанбурхан өвчний дэгдэлтийн үеийн дархлаажуулалтыг зохион байгуулах түр зааврыг баримтлан дархлаажуулах 430 хүүхдийн судалгааг гарган, 316/64%/ дархлаажуулалтад хамруулсан.Улаанбурханы нөхөн дархлаажуулалтад хамрагдвал зохих 3717 хүүхдээс 2656 хүүхэд нөхөн дархлаажуулалт болон цахимд нөхөн бүртгэж, хамралт 71% буюу 39%-иар нэмэгдсэн байна.	100
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ 2.2. ДАРХЛААЖУУЛАЛТ БҮХИЙ ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ТАНДАЛТ АЮУЛГҮЙ ДАРХЛААЖУУЛАЛТЫН ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛЖ ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ						
2.2.1	Тархвар судлалын заалт болон сайн дураар хийгдэх дархлаажуулалтыг нэмэгдүүлэх	Вакцины төрөл хамрагдсан хүний тоо	-	-	Аймгийн хэмжээнд 1775 эрүүл мэндийн ажилтны дархлаажуулалтын судалгааг авахад сүүлийн 5 жил дотор вакцин хийлгэсэн 94, улаанбурханаар өвдсөн 356, жирэмсэн 56, татгалзсан 217, дахин тодруулах шаардлагатай 220, хамрагдвал зохих 832 байна.Улаанбурхан, улаануудын дархлаажуулалтад хамрагдвал зохих 832 эрүүл мэндийн байгууллагын ажилтнаас 733/88,1%/ ажилтан хамрагдаад байна. Мөн тархвар судлалын заалтаар улаанбурхан, улаануудын вакцинд 1863 хүн хамрагдсан. 1761 эх төрснөөс 27/1,5%/ В вирус тээгч эх төрсөн байна. Гепатитын В вирусийн халдвартай эхээс төрсөн 3 нярайд 12 цагийн дотор гепатитын В вирусийн эсрэг вакцины эхний тун, В вирусийн эсрэг өвөрмөц иммуноглобулин (HBIG) хийж цаашид өвчлөхөөс сэргийлэх арга хэмжээг авч ажилласан Ажил мэргэжлийн шаардлагаар балнадын вакцинд 59 хүн хамрагдсан. Балнадын вакцин, бактерифагийг танилцуулах сургалт 2 байгууллагад хийж, 56 хүн хамрагдсан. Элэгний В вирусийн эсрэг сайн дурын дархлаажуулалтад давхардсан тоогоор 1607 хүний папиллома вирусийн эсрэг вакцин 47, хачигт энцефалитын вакцинд 500 хүн тус тус хамрагдсан. Өнгөрсөн оны мөн үеэс дархлаажуулалтад хамрагдсан хүний тоо 3% нэмэгдсэн байна.	100
2.2.2	Вакцины хадгалалт тээвэрлэлтийн хэмийн хяналтыг дархлаажуулалтын	Хяналтын тоо, зөвлөмж	4	4	Дархлаажуулалтын цэгүүдэд 3 удаа дэмжлэгт хяналт хийн, зөвлөмж өгч ажилласан. Зөвлөмжийн хэрэгжилт 89,6% байна.	70

	нэгжүүдэд хийсэн байна.					
2.2.3	Дархлаажуулалтын урвал хүндрэлийн тохиолдол бүрийг бүртгэн мэдээлж, дүн шинжилгээ хийх.	Бүртгэгдсэн тохиолдлын тоо, хариу арга хэмжээний хэрэгжилтийн хувь	2	100%	Товлолын дархлаажуулалтад хамрагдсан 7980 хүүхдийн дархлаажуулалтын дараах урвал хүндрэлийн тандалт хийж, хэсэг газрын урвал 2, 37,5 хэмээс дээш халуурсан 8, ерөнхий урвалын 2 тохиолдлыг бүртгэж мэдээлсэн. Голомтын болон нэмэлт дархлаажуулалтад хамрагдсан 1860 хүнд дархлаажуулалтын урвал хүндрэлийн тандалт хийхэд, ноцтой, хүнд урвал илрээгүй байна. Дархлаажуулалттай холбоотой 3 удаагийн гомдлыг шийдвэрлэж ажилласан.	100
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ 2.3. ДАРХЛААЖУУЛАЛТ БҮХИЙ ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ТАНДАЛТ ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЧАДАВХЫГ САЙЖРУУЛАХ						
2.3.1	Дэлхий нийтээр халдварт саа өвчнийг устгах хүртэл “Халдварт саа өвчнийг устгах байдал”-аа хадгалах, тандалтын мэдрэг чанарыг сайжруулах.	Тандалтын сорьцын тоо	0	20	Цочмог сул саажилтын тандалтыг эрчимжүүлэх, сорьц авах арга техникийн сургалтыг Халдварт өвчин судлалын үндэсний төвтэй хамтран зохион байгуулж, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, сум, өрхийн эрүүл мэндийн төв, хувийн хэвшлийн хүүхэд, мэдрэлийн 17 эмч хамрагдсан. “Халдварт саа өвчнийг устгах байдал”-аа хадгалах, тандалтын сорьцыг 1-5 насны 20 хүүхдээс цуглуулж хүргүүлсэн.	100
2.3.2	Улаанбурхан болон цочмог сул саажилт мэдээлэгдсэн тохиолдолд эрсдэлийн үнэлгээ хийж хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах.	Хариу арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	-	100%	Улаанбурхан өвчний тархалтыг хязгаарлах хүрээнд аймгийн Засаг даргын 2024 оны А/586 дугаар захирамжаар батлагдсан салбар дундын ажлын хэсэг, Эрүүл мэндийн газрын даргын 2025 оны А/49 дугаар тушаалаар байгуулагдсан шуурхай удирдлагын 5 баг 28 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж, эрсдэлийн үнэлгээ 3 удаа хийж, тандалт судалгаа сэжигтэй тохиолдлын хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулж, эрсдэлийн үеийн мэдээллийг идэвхжүүлж, ажилласан. Орон нутгийн 2025 оны төсвөөс нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед тохиолдол удирдлагын тогтолцоог дэмжих зорилгоор 30 сая, Онцгой комиссын зардлаас 100 сая төгрөгийг шийдвэрлүүлж, бэлэн байдлыг хангасан. Бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудад 3 удаагийн дэмжлэгт хяналт хийж, зөвлөмж өгч, 93,6% хэрэгжүүлж ажиллалаа. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн яаралтай тусламж, эрчимт эмчилгээний тасаг, халдвартын тасгийн эрчимт эмчилгээний хэсэг, тусгаарлан ажиглах өрөөний бэлэн байдалд салбарын хяналтын газрын төлөвлөгөөт бус шалгалт хийж, зөрчил дутагдлыг арилгуулах чиглэлээр хамтарсан хурал хийн, шийдвэрлэж ажилласан. Зайлшгүй шаардлагатай эм, тариа, эмнэлгийн хэрэгсэл, цус, цусан бүтээгдэхүүний нөөцийг 7 хоног бүр гарган, үнэлгээ өгч ажилласан. Эрүүл мэндийн яамнаас зохион байгуулсан 2 удаагийн хурал, 7 удаагийн цахим сургалтад 376 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан. Улаанбурхан өвчний хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах чиглэлээр эрүүл мэндийн байгууллагуудын	100

					удирдлага, холбогдох мэргэжлийн эмч, сувилагч, вакцинаторууд, хүүхдийн байгууллагын эмч нарт чиглэл тус бүрээр 4 удаагийн хурал хийж, үүрэг чиглэл өгч ажилласан. Халууралт, тууралттай хам шинжийн тандалт, улаанбурхан өвчний эмнэлзүй, илрэх шинж тэмдэг, ялган оношилгоо авах арга хэмжээний талаар эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд зориулсан дотоодын сургалт 14 удаа зохион байгуулж, нийт эмч, эмнэлгийн ажилчдын 84,6% хамрагдсан.Цочмог сул саажилтын 1 тохиолдлыг бүртгэж, мэдээлэн, ДЭМБ-ын шалгуурыг хангаж ажилласан.	
2.3.3	Цочмог, халууралт тууралтат хам шинжийн тандалтыг эрчимжүүлж, мэдээлэгдсэн улаанбурхан, улаануудын сэжигтэй тохиолдол бүрийг лабораториор баталгаажуулах	Сорьцын тоо	1	1	Халууралт тууралттай хамж, сэжигтэй тохиолдлын тандалтыг 21 нэгжид хийн, өдөр бүр ХӨСҮТ-д цахимаар мэдээлж байна. Улаанбурхан өвчний сэжигтэй 100 тохиолдолд лабораториор баталгаажуулсны 45/45%/ эерэг тодорхойлогдож, хариу арга хэмжээг авч ажилласан.	100
2.3.4	Дархлаажуулалт бүхий бусад халдварт өвчний тандалт зохион байгуулах.	Бүртгэгдсэн тохиолдолд тандалт хийсэн тоо	-	100%	Гахайн хавдар өвчний сэжигтэй 15 тохиолдлын судалгааг хийж, 10 бүртгэн мэдээлж, хариу арга хэмжээг авч ажилласан. Гахайн хавдар өвчний тохиолдол өнгөрсөн оны мөн үеийн түвшинд байна.	100
2.3.5	Вакцины тасралтгүй байдлыг хангах, шаардагдах вакцин дагалдах хэрэгслээр тасралтгүй хангасан байна.	Улирал бүр, шаардлагатай тохиолдолд тухай бүр татан авна	4	4	Халдварт өвчин судлалын үндэсний төв болон Зоонозын өвчин судлалын үндэсний төвөөс нийт 4 удаагийн татан авалтаар 20 нэр төрлийн 64350 хүн тун вакцин, 27900 дагалдах хэрэгслийг татан авч дархлаажуулалтын тасралтгүй хэвийн үйл ажиллагааг ханган ажилласан. Улаанбурхан өвчний нөхцөл байдалтай холбогтойгоор 1000 хүн тун улаанбурхан, улаануудын вакцин татан авч, дархлаажуулсан.	100
2.3.6	Дархлаажуулалтын цахим бүртгэлийг өргөжүүлэх	Цахим бүртгэлийн хувь	90%	95%	Сум өрхийн эрүүл мэндийн төвүүд дархлаажуулалтын цахим программ/vis.health.gov.mn/-д мэдээллийг оруулж хэвшсэн. 2006-2018 онд 22,491 төрсөн хүүхдийн судалгааг гарган, дархлаажуулалтын мэдээллийг цахим бүртгэл (https://health.gov.mn/)-д нөхөн бүртгэх арга хэмжээг зохион байгуулж, 21414/95,2%/ хүүхдийн мэдээллийг бүртгээд байна. Улаанбурхан, гахайн хавдар,улаануудын эсрэг дархлаажуулалтын бүртгэлд бүртгэгдээгүй болон хоцорсон 2635 хүүхдүүдийн дунд хийсэн судалгаа хийсэн. Үр дүн: • Манай аймгийн харьяалалтай хүүхэд 59.5% (1569), харьяаллын бус хүүхэд 40.4% (1066) эзэлж байна.	100

					- Судалгаанд хамрагдсан 2635 хүүхдийн 89.2%(2351) товлотл дархлаажуулалтад хамрагдсан байна. - Дархлаажуулалтаас хоцорсон 284 хүүхдийн 47.8%(136)-ийг судалгааны явцад нөхөн дархлаажуулсан ба 36 хүүхдэд нөхөн дархлаажуулалтад хамрагдах зөвлөгөө өгсөн. - Дархлаажуулалтад хамрагдах боломжгүй 112 хүүхэд байснаас 76%(85)нас барсан, 12,5%(14) татгалзсан, 5.3%(6) вакцины эсрэг заалттай, 3,5%(4)ДДУХ өгсөн, 2,7% (3) гадаадад амьдарч байна. - Дархлаажуулалтаас хоцорсон шалтгааныг судлахад эрүүл мэндийн боловсрол дутмаг, эцэг эхийн хайхрамжгүй байдал 27.1%, эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 18.6%, иргэн болон ЭМБ уялдаа холбоо сул 12.6%, шилжилт хөдөлгөөн 18%, КОВИД-19 хөл хорио 6,7%, өвчнөөр түр хойшилсон 12.3%, ДДУХ-тэй холбоотой 4,7% байна. - Дархлаажуулалтын цахим бүртгэлд 1867(78.6%) хүүхдийн мэдээллийг нөхөн оруулж, 508(21.3%) хүүхдийн эцэг эх асран хамгаалагч нарт бүртгэлд оруулахыг зөвлөсөн.	
2.3.7	Вакцинаторуудад зориулсан мэргэшүүлэх сургалтыг тасралтгүй зохион байгуулах.	Зохион байгуулсан сургалтын тоо	4	8	Дархлаажуулалтын сувилагч нарт мэдлэг сэргээх, чадавхжуулах 10 удаагийн 10 нэгжийн 170 хүн давхардсан тоогоор хамрагдсан. Улаанбуруханы дэгдэлт нэмэгдсэнтэй уялдуулан зохион байгуулж буй "Дархлаажуулалтын сувилахуй" төрөлжсөн мэргэшлийн сургалтад 6 сувилагч хамрагдсан.	100
2.3.6	Сургууль, хүүхдийн томуугийн хамруулах цэцэрлэгийн улирлын вакцинд	Дархлаажуулалтын хамралтын хувь	50%	50%	Улирлын томуугийн дархлаажуулалтад зорилтот бүлгийг 100% хамруулсан.	100
ЗОРИЛТ 3. ОЛОН НИЙТ, ИРГЭНИЙ НИЙГМИЙН ОРОЛЦООТОЙ СҮРЬЕЭГИЙН ЦОГЦ ЧАНАРТАЙ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭГ ХҮН АМД ТАСРАЛТГҮЙ ХҮРТЭЭМЖТЭЙ ХҮРГЭЖ, 2030 ОНД СҮРЬЕЭГИЙН ХАЛДВАРЫН ТАРХАЛТЫГ ТАСЛАН ЗОГСООХ ДЭЛХИЙН СҮРЬЕЭГИЙН ЗОРИЛТЫН БИЕЛЭЛТИЙГ ХАНГАХ						
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ 3.1. СҮРЬЕЭ ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ ТАНДАХ ХЯНАХ ТОГТОЛЦООНЫ ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЗАМААР СҮРЬЕЭГИЙН ИЛРҮҮЛЭЛТИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ.						
3.1.1	Сүрьеэгээр эрсдэлт бүлгийн хүн амын судалгааг өвчлөх гаргаж бүртгэлжүүлэх.	Зорилтот бүлгийн хүн амыг бүртгэлжүүлсэн хувь	90%	95%	Тайлант хугацаанд Эрүүл мэндийн сайдын 2024 оны 30 дугаар тушаалын дагуу аймгийн хэмжээнд сүрьеэгийн идэвхтэй илрүүлэлтэд хамрагдвал зохих эрсдэлт бүлгийн 3790 хүний судалгааг гарган шинэчилсэн. Сүрьеэгээр өвчлөх эрсдэл өндөртэй үндсэн бүлэг 11,3%/427/, Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж хязгаарлагдмал байдалтай 12,7%/481/, Эрүүл мэндийн шалтгаантай 67,7%/2565/, ажлын байрны өвөрмөц орчин эрсдэлтэй 8,3%/317/ тус тус эзэлж байна.	100

3.1.2	Сүрьеэгээр өвчлөх эрсдэлт бүлгийн хүн амын илрүүлэг, үзлэг, шинжилгээнд хамруулах.	Хамрагдсан хувь	40%	50%	Тайлант хугацаанд эрсдэлт бүлгийн 1872/74.1%/ хүнийг идэвхтэй илрүүлэгт хамруулж, 198 хүнд сорил, 15 хүнд цэрний шинжилгээ хийсэн. Цэрний шинжилгээгээр батлагдсан сүрьеэгийн тохиолдол бүртгэгдээгүй. Сорил эерэг гарсан 50 хүнээс 8 тохиолдлыг /урьдчилан сэргийлэх 3+эмэнд мэдрэг сүрьеэ 5 /сүрьеэгийн эмчилгээ хяналтанд хамруулсан. Үлдсэн эерэг 29 тохиолдлуудыг ажиглах, 15 тохиолдлыг онош дотруулах шаардлагатай байна.	100
3.1.3	Төрийн болон төрийн бус байгууллагын зохион байгуулж буй идэвхтэй илрүүлэг, үзлэг шинжилгээний явцад дэмжлэгт хяналт хийх.	Дэмжлэгт хяналтын тоо	1	2	Сүрьеэгийн идэвхтэй илрүүлэг зохион байгуулж буй сум, өрхийн эрүүл мэндийн төв болон сүрьеэгийн диспансер, сүрьеэгийн тасагт бэлтгэл ажил хангуулах 2 баг хуваарийн дагуу дэмжлэгт хяналт хийж гүйцэтгэн, анхаарвал зохих 6 асуудлыг тухай бүр шийдвэрлэж ажилласан. Мөн илрүүлэг үзлэгийг зохион байгуулж буй цэгүүдэд өдөр бүр үзлэг эхлэхийн өмнөх, явцын, төгсгөлийн хяналтыг хийж, үнэлгээний хуудас хөтөлж, арга хэмжээг тухай бүр авч ажиллалаа. Жаргалант сумын эрүүл мэндийн төвд Монголын сумын эмч мэргэжилтнүүдийн холбооноос хэрэгжүүлж буй “Глобаль сангийн дэмжлэгтэй “сүрьеэгийн тусламж, үйлчилгээг сумын эрүүл мэндийн төвийн түвшинд бэхжүүлэх” дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд1 удаа дэмжлэгт хяналт хийсэн. Хөтөлбөрийн хэрэгжилт 89% байна.	100
3.1.4	Сүрьеэгийн тусламж үйлчилгээ заавар журмын хэрэгжилтийг хангах нэгдсэн төлөвлөгөөг хангаж ажиллах.	Сүрьеэгийн диспансерд хүрч ажилласан хувь	-	50%	Сүрьеэгийн тусламж үйлчилгээг сайжруулах чиглэлээр зохион байгуулах үйл ажиллагааны нэгдсэн удирдамж батлуулан салбаруудад хүргүүлж ажиллаж байна. Төлөвлөгөөний биелэлт 88,5% байна. “Сүрьеэгийн тусламж үйлчилгээний өнөөгийн байдал” уулзалт, хэлэлцүүлгийг эрүүл мэндийн салбарын хүрээнд зохион байгуулж, 2024 оны 5 нас баралт, эмчилгээний хяналт алдагдлын 10 тохиолдлыг хэлэлцэж, тохиолдол бүрээр зураглалыг нарийвчлан гаргаж, дахин хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн. Энэхүү хэлэлцүүлгээр 4 арга хэмжээ зохион байгуулах шийдвэр гаргасан. Үүнээс 2 арга хэмжээг хэрэгжүүлж, 2 нь хэрэгжих шатанд байна. Тайлант хугацаанд халдварт өвчний 684 тохиолдол бүртгэгдэж, өнгөрсөн оны мөн үеэс 2,9 промиллоор буурсан байна. Сүрьеэгийн өвчлөл 70 тохиолдол бүртгэгдэж, 10000 хүн амд 6,6 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 1,7 промиллоор буурсан байна.	100
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ 3.2. ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНД ИРГЭН ТӨВД ХАНДЛАГЫГ ХЭВШҮҮЛЖ АНХАН ШАТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ОРОЛЦООГ САЙЖРУУЛАХ ЗАМААР СҮРЬЕЭГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВЛӨРЛИЙГ СААРУУЛАХ						
3.2.1	Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын үзүүлэх сүрьеэгийн тусламж үйлчилгээний зураглалыг хэрэгжүүлэх.	Байгууллагын тоо	-	10	Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/38 дугаар тушаалын дагуу сум, өрхийн эрүүл мэндийн төвд сүрьеэгийн тусламж үйлчилгээг үе шаттайгаар үзүүлж байна. Жаргалант сумын эрүүл мэндийн төв, 6 өрхийн эрүүл мэндийн төвд 9 хүн хяналттай эмийн эмчилгээ хийлгэж байна. Идэвхтэй илрүүлэг шинжилгээг хуваарийн дагуу сум, өрхийн эрүүл мэндийн төвд зохион байгуулсан. Жаргалант сумын эрүүл мэндийн төвөөс 15 цэрний сорьцыг тээвэрлэсэн байна. Цаашид	70

					сумын сорьц тээвэрлэлтийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.	
3.2.2	Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын үзүүлэх сүрьеэгийн тусламж үйлчилгээнд сургалт, дэмжлэгт хяналт хийх.	Дэмжлэгт хяналтын тоо	1	2	Сүрьеэ өвчний оношилгоо, хяналт, эмчилгээнд анхаарах асуудлаар чадавхжуулах 2 удаагийн сургалтад анхан болон лавлагаа шатлалын 124, хүүхдийн байгууллагын 56 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамруулсан. Эрүүл мэндийн газрын даргын баталсан удирдамжийн дагуу сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 1 удаа дэмжлэгт хяналт хийж, зөвлөмж өгсөн. ХӨСҮТ-ийн СТСА-ны сүрьеэгийн тусламж үйлчилгээнд хийсэн дэмжлэгт хяналтаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны 23 арга хэмжээ бүхий төлөвлөгөө батлуулан, хэрэгжилтийг ханган ажилласан. Зөвлөмжийн биелэлтийг чиглэл тус бүрээр гарган үнэлгээ өгч ажиллахад бүрэн хэрэгжсэн 18, хэрэгжих шатанд байгаа 2, биелэл гаргах хугацаа болоогүй 1, хэрэгжээгүй 1 арга хэмжээ байна. Зөвлөмжийн биелэлт 90,5% байна.	100
3.2.3	Сүрьеэгийн диспансерын халдвараас сэргийлэх хянах нөхцөлийг сайжруулах үйлчлүүлэгчид ээлтэй орчин бүрдүүлэх.	Шалгуур үзүүлэлт	30%	50%	Сүрьеэгийн тусламж, үйлчилгээг сайжруулах ажлын хүрээнд 1 удаагийн уулзалт зохион байгуулж, эрүүл мэндийн салбарын холбогдох 15 мэргэжилтэн оролцсон. Уулзалтаар 2024 онд сүрьеэгийн нас барсан болон эмчилгээний хяналт алдагдсан тохиолдол, Сүрьеэгийн диспансерын халдвараас сэргийлэх хянах нөхцөлийг сайжруулах үйлчлүүлэгчид ээлтэй орчин бүрдүүлэх асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн. Сүрьеэгийн диспансер нь халдвараас сэргийлэх хянах нөхцөлийг 90% ханган ажиллаж байна. Амбулаторийн үзлэг, урьдчилан сэргийлэх үзлэг тусдаа хийдэг өрөөтэй, хүлээлгийн хэсэг тохижуулсан, агааржуулалт ба бусад инженерийн тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан, засвар үйлчилгээ тогтмол хийж байна. Лабораторийн хэсэг тусдаа нэг урсгалтай зохион байгуулагдсан тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан.	70
3.2.4	Сүрьеэгийн далд халдвартай тохиолдлын эмчилгээнд хамрагдалтын хувийг нэмэгдүүлэх.	Эмчилгээн д хамрагдалтын хувь	20%	30%	2025 оны эхний 11 сарын байдлаар шинэ эмэнд мэдрэг сүрьеэ 71, дахилт 6 нийт 77 тохиолдол бүртгэгдсэн байна. Оношоор ангилбал: - Уушгины халдвартай /шинэ+дахилт/-27 - Уушгины халдваргүй 27 - Уушгины бус эрхтэний сүрьеэ-23 Нийт эрсдэлт бүлгийн 256 хүнд сүрьеэгийн сорил тариа тарьж, сорил эерэг 38 тохиолдлоос 7 тохиолдлыг эмэнд мэдрэг сүрьеэгийн эмчилгээнд, 10 тохиолдол урьдчилан сэргийлэх эмчилгээнд тус тус хамруулсан. Үлдсэн тохиолдлыг ажиглах, онош дотруулах шаардлагатай. Сүрьеэгийн далд халдвартай тохиолдлын эмчилгээнд хамрагдсан хувь 44,7% байна. БООТ-д эмнэлэгт суурилсан сүрьеэгийн илрүүлгийг нэмэгдүүлэх	100

					ТРИАЖ үйл ажиллагааг эхлүүлсэн. ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн тандалт судалгааны албатай хамтран Сүрьеэгийн урьдчилан сэргийлэх эмчилгээний асуудал сэдвээр сургалт зохион байгуулж, 20 хүн хамрагдсан.	
3.2.5	Сүрьеэгийн хавьтлын давтан хяналтыг сайжруулах.	Давтан хяналтын хувь	10%	20%	Сүрьеэтэй өвчтөний өрх болон ойрын хавтал 1700 хүний судалгааг баг тус бүрээр гаргаж, илрүүлэг үзлэгт 1302 /76,5%/ хүнийг хамруулсан. Туберкулины сорил эерэг гарсан 21 хүнээс 1 тохиолдлыг эмэнд мэдрэг сүрьеэгийн эмчилгээнд хамруулсан. Давтан хяналтад хамрагдсан сүрьеэгийн хавьтлын хувь 34,1% байна.	70
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ 3.3. ИНОВАЦИ,ШИНЭ ДЭВШИЛТЭД ТЕХНОЛОГИЙГ СҮРЬЕЭГИЙН ОНОШЛОГОО ЭМЧИЛГЭЭНД ТУРШИХ НЭВТРҮҮЛЭХ ЧАДВАХТАЙ ХҮНИЙ НӨӨЦИЙГ ТАСРАЛТГҮЙ БЭЛТГЭХ ЗАМААР ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ						
3.3.3	Сүрьеэгийн батлагдсан тохиолдолд эмэнд тэсвэржилтийг /Рифампицин /тодорхойлох шинжилгээ хийх.	Шинжилгээнд хамруулсан хувь	85%	90%	Тайлант хугацаанд сүрьеэгийн диспансераар үйлчлүүлсэн, тасагт хэвтэж байгаа, ойрын хавьтлын 279 хүнд GeneXpert-ээр молекул биологийн шинжилгээ хийснээс 14 тохиолдол батлагдсан. GeneXpert хийсэн 279 тохиолдол бүрт рифампицин эмэнд тэсвэржилтийг шалгахад рифампицин батлагдсан тохиолдол илрээгүй байна.	100
3.3.4	Эмийн гаж нөлөөг бүртгэх, мэдээлэхэд эмч, мэргэжилтнийг сургах, бүртгэгдсэн гаж нөлөөнд дүн шинжилгээ хийх.	Сургалтад хамрагдсан эмч, мэргэжилтний тоо	-	11	Тайлант хугацаанд сүрьеэгийн эмийн гаж нөлөө илрээгүй байна.	70
3.3.5	Сүрьеэ судлалын мэргэжлийн эмч мэргэжилтнийг батлагдсан орон тоогоор ажиллуулах.	Сүрьеэгийн эмч, мэргэжилтний орон тоо	1	1	Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Сүрьеэгийн тасаг, Диспансерт 3 их эмч, 7 сувилагч, 1 төслийн зохицуулагч, 1 лаборант нийт 12 хүний бүрэлдэхүүнтэй бүрэн орон тоогоор тусламж үйлчилгээг үзүүлж байна.	100
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ 3.4. СҮРЬЕЭГЭЭС СЭРГИЙЛЭХ, ЭРТ ИЛРҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНД ИРГЭД БОЛОН ОРОН НУТГИЙН ТӨР, ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА, АЖИЛ ОЛГОГЧИД, ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГЫН ОРОЛЦОО, ХАРИУЦЛАГЫГ НЭМЭГДҮҮЛЭХ, ТЭГШ БУС БАЙДАЛ, ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТЫГ БУУРУУЛАХ, ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ ЦОГЦ АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ЧИГЛЭСЭН УХУУЛГА НӨЛӨӨЛЛИЙН АЖЛЫГ ЭРЧИМЖҮҮЛЭХ						
3.4.1	Сүрьеэгийн сургалт, сурталчилгааны төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх.	Төлөвлөгөөний хэрэгжилт	-	50%	2025 онд сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлийн мэдээлэл, сургалт, сурталчилгаанд нийт 22476 иргэнийг харуулж, мэдээлэл, сургалт, сурталчилгаанд хамрагдсан хүний тоо 3 дахин өссөн байна. Сүрьеэтэй тэмцэх дэлхийн өдрийн хүрээнд эрүүл мэндийн бүх шатны байгууллагуудыг оролцуулсан өдөрлөгийг төв талбайд зохион байгуулж, ажилласан. Өдөрлөгт эрүүл мэндийн салбарын 25 байгууллын 125 эмч, эмнэлгийн мэргэжилтэн оролцож, 2500 иргэнд зөвлөмж, витамин түгээж ажилласан. Мөн 75 байгууллагад сургалт	100

					хийж, 1125 хүнийг хамруулсан. FM радиод 1, телевизэд 1 удаа мэдээлэл өгч, 2000 гаруй хүнд хүргэсэн. “Тийм-Бид сүрьеэг устгаж чадна” рийл 1, бичлэг 1, ярилцлага 1 цахим хуудаст байршуулж, 16726 хүн үзэж, 65 цахим хуудаст түгээсэн байна. Эрүүл мэндийн салбарын 15, орон нутгийн 4 цахим хуудсаар мэдээлэл, сэрэмжлүүлэг зөвлөмж түгээн ажиллаж байна.	
3.4.2	Эмзэг бүлгийн сүрьеэтэй иргэдийг нийгмийн халамж дэмжлэгт хамруулах.	Нийгмийн дэмжлэгт хамрагдсан хувь - 20%	17.5%	20%	Монголын сүрьеэтэй тэмцэх нийгэмлэгийн сайн дурын 2 идэвхтэнтэй хамтарч сүрьеэ өвчнөөр эмчлэгдэж байгаа 16 иргэний эмийг хяналттай уулгасан. Шинээр бүртгэгдсэн 70 тохиолдлын 20,5% нийгмийн дэмжлэгт хамрагдсан.	70
ЗОРИЛТ 4. БЭЛГИЙН ЗАМААР ДАМЖИХ ХАЛДВАР ХҮНИЙ ДАРХЛАЛ ХОМСДЛЫН ВИРУСИЙН ХАЛДВАРААС СЭРГИЙЛЭХ,ЭРТ ИЛРҮҮЛЭЛТИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ,ИРГЭН ТӨВТЭЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ЦОГЦ ЧАНАРТАЙ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЖ ХАЛДВАРЫН ТАРХАЛТЫГ БУУРУУЛАХ						
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ 4.1. БЗДХ, ХДХВ, ДОХ-ЫН ХАЛДВАРААС СЭРГИЙЛЭХ, ОНОШИЛГОО, ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ.						
4.1.1	ХДХВ, БЗДХ-ын тусламж, үйлчилгээ үзүүлдэг эмч, мэргэжилтний хүний нөөцийг бүрдүүлэх.	Тушаал, шийдвэрт заасан орон тоо	-	70%	БОЭТ-ийн БЗДХК нь бүтэц орон тооны хувьд 1 эмч, 1 эмнэлгийн мэргэжилтэнтэй бөгөөд бусад ЭМБ-уудтай хамтран мэдээллийн урсгалын дагуу бүртгэл мэдээллийг хянаж, хариу арга хэмжээг авч ажиллаж байна.	70
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ 4.2. БЗДХ, ХДХВ, ДОХ-ЫН ВИРУСИЙН ХАЛДВАРААС СЭРГИЙЛЭХ ТАНДАХ ХЯНАХ ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛЭХ						
4.2.1	БЗДХ ХДХВ, ДОХ-ын идэхтэй тандалт эрт илрүүлгийн үйл ажиллагааг зохион байгуулах.	Илрүүлэгт хамрагдсан хүний тоо	800	840	БОЭТ-ийн БЗДХК, СӨЭМТ-үүдэд ХДХВ/ДОХ, тэмбүүгийн түргэвчилсэн сорилоор 9546 иргэнийг хамруулан 164 тохиолдлыг лавлагаа шатлал руу шилжүүлсэн. Цэрэг татлагын 2 удаагийн урьдчилан сэргийлэх үзлэг, БЗДХ-ын эрт илрүүлэгт, эрэгтэйчүүдийн урьдчилан сэргийлэх үзлэг, хорих ангийн урьдчилан сэргийлэх үзлэг, ААНБ-ууд, МСҮТ, их дээд сургуулийн эрэгтэйчүүдийн дунд зохион байгуулсан эрт илрүүлэг үзлэг, шинээр хяналтад хамрагдсан жирэмсэн эх 1439 нийт 25995 иргэнийг ДОХ/Тэмбүү илрүүлэх шинжилгээнд хамруулсан байна.	70
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ 4.3. ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНД ИРГЭН ТӨВТ ХАНДЛАГЫГ ХЭВШҮҮЛЖ БЗДХ, ХДХВ, ДОХ-ЫН ВИРУСИЙН ХАЛДВАРААС СЭРГИЙЛЭХ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ.						
4.3.1	ХДХВ-ийн халдвартай хүнд мэдээлэл өгөх сургалт, уулзалтыг зохион байгуулах, хяналтын үйлчлүүлэгчдийн эмчилгээ, тусламж үйлчилгээний хамрагдалтыг	Тусламж үйлчилгээн ий хамрагдалтын хувь	92%	95%	БЗДХ-аас сэргийлэх чиглэлээр сургалтад БГ, СӨЭМТ 9, ЕБС-иуд, ТББ-уудтай хамтран зохион байгуулж, давхардсан тоогоор 9250 сурагч, 2800 гаруй эцэг, эх, асран хамгаалагч нарын төлөөллийг хамруулаад байна. Мөн орон нутгийн удирдлагууд, төрийн болон ТББ, ЭМС-ын төлөөлөл, сурагч багш бэлтгэх сургалтад сурагчид болон эцэг, эх, асран хамгаалагч нарын төлөөллөөс 300 сурагч багш бэлтгэн сургууль тус бүр арга хэмжээг хамтран зохион байгуулж хамтран ажилласан. Дэлхийн ДОХ-той тэмцэх өдрийг “Асуудлыг	100

	нэмэгдүүлэх				шийдье, ДОХ-ын эсрэг хариу арга хэмжээг сайжруулъя” уриан дор өдөрлөг зохион байгуулж 3 сэдвийн хүрээнд сургалт, танин мэдэхүйн АХА тэмцээн явуулж, сурагчдын идэвх оролцоог нэмэгдүүлэн мэдлэгийг бататган нийт 550 оюутан, сурагчдыг хамруулж эхний 3 байр эзэлсэн сурагчдад батламж, дурсгалын зүйлсийг гардуулсан. “Улаан тууз” сэдвээр ЕБС-ын сурагчдын дунд богино бичлэгийн уралдаан зарлаж, 3 сургуулийн 150 гаруй хүүхдүүд хамрагдсан байна. Шилдэг багаар шалгарсан 1 багийг 1,000,000 төгрөгөөр шагнаж урамшуулсан.	
4.3.2	ХДХВ-ийн халдвартай амьдарч буй хүмүүсийн товлोलт шинжилгээний хамрагдалт, эмийн тууштай хэрэглээг үнэлж, хариу арга хэмжээ авах.	Шинжилгээ ний хамралтын хувь	90%		БЗДХ-ын нийт 162 өвчлөл бүртгэгдсэнээс • Тэмбүү-49 • Төрөлхийн тэмбүү-2 • Тэмбүү өвчтэй жирэмсэн - 5 • Заг хүйтэн -19 • Трихомониаз -38 • Бэлгийн замын мөөгөнцөр -31 • Нянгийн гаралтай үтрээний үрэвсэл 18, нийт 162 өвчлөлийг бүртгэн, карт нээж, хавьтлын хамт эмчилгээнд хамрууллаа. Нийт 130 хавьтал бүртгэгдэж, хавьтлаас тэмбүүгийн өвчлөл 5, хавьтлын хамт 100% оношлон, эмчлэгдсэн байна.	70
4.3.3	Хорих ангийн эмч, эмнэлгийн мэргэжилтний БЗДХ, ХДХВ-ийн халдвар илрүүлэх, оношлох, эмчлэх чадавхийг сайжруулах.	Хамрагдсан хүний тоо	-	1	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 437 дугаар хорих ангийн эмч, сувилагч БЗДХ, ХДХВ-ийн халдвар илрүүлэх, оношлох, эмчлэх чиглэлээр чадавхжуулах сургалтад хамрагдсан.	70
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ 4.4. ЭРСДЭЛТ БҮЛГИЙН ХҮН АМД ЧИГЛЭСЭН БЗДХ, ХДХВ, ДОХ-ЫН ВИРУСИЙН ХАЛДВАРААС СЭРГИЙЛЭХ, ЭРТ ИЛРҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНД ОЛОН НИЙТ ,ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛАГАЛАГЫН ОРОЛЦООГ ТОГТВОРТОЙ ХАНГАХ ЗАМААР ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ,ЖЕНДЭРИЙН ТЭГШ БУС БАЙДАЛ, ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТЫГ БУУРУУЛАХ , ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ ЦОГЦ АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ						
4.4.1	Эмэгтэй биеэ үнэлэгчдэд чиглэсэн БЗДХ, ХДХВ, ДОХ-оос сэргийлэх, мэдлэг, хандлага зан үйл өөрчлөг сургалт, уулзалт тогтмол зохион байгуулах.	Зохион байгуулсан сургалт, уулзалт, хамрагдсан хүний тоо	20	30	Төгс бүсгүйчүүд ТББ-ын орхон аймгийн салбар болох Амурлин тэнгис ТББ, болон Баян-Өндөр сумын 14 багтай хамтран 360 эмэгтэй биеэ үнэлэгчид чиглэсэн 13 сэдвийн хүрээнд БЗДХ, ХДХВ, ДОХ-оос сэргийлэх, мэдлэг, хандлага зан үйл өөрчлөх сургалт, уулзалтыг 12 удаа зохион байгуулан ажилласан.	70
4.3.2	Нотолгоод суурилсан үр дүнтэй аргыг ашиглан эмэгтэй биеэ үнэлэгчдийг ХДХВ, БЗДХ-ыг илрүүлэх шинжилгээ, НҮЭМ-ийн	Үйлчилгээнд хамрагдсан хүний тоо	20	30	Төгс бүсгүйчүүд ТББ-ын орхон аймгийн салбар болох Амурлин тэнгис ТББ, болон Баян-Өндөр сумын 14 багтай хамтран 12 удаагийн сургалт,үзлэг шинжилгээнд 360 эмэгтэй биеэ үнэлэгчидийг үзлэг, шинжилгээнд хамруулсан.	100

	үйлчилгээнд зуучлах хамруулах, илэрсэн өвчлөлийг тусламж, үйлчилгээнд хамруулах ажлыг тогтмол зохион байгуулах.					
4.3.3	ЭБЭ олон нийтийн хэрэгцээ, онцлогт тохирсон ХДХВ, БЗДХ-аас сэргийлэх үйл ажиллагааг тогтмол хэрэгжүүлэх	Зохион байгуулсан үйл ажиллагаа, үйлчилгээн д хамрагдсан хүний тоо	20	20	Глобаль сангийн дэмжлэгтэйгээр “Залуучуудын эрүүл мэнд” ТББ-ын үйл ажиллагааг Орхон аймагт хэрэгжүүлэхээр 1 удаагийн уулзалт зохион байгуулсан. Уулзалтаар Орхон аймагт тус байгууллагын салбарыг байгуулан хамтран ажиллахаар шийдвэрлэсэн.	70
